

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Тооллогын комиссын тогтоол, хурлаас гарах
шийдвэрүүдийг батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг баталсугай.
2. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон 63.1 хувийн саналаар санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлт батлав
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов. Үүнд:

Ердийн гишүүнээр:

а) Лутаагийн Буянбатыг	774,878	саналын эрхээр
б) Лутаагийн Энхнасанг	769,636	саналын эрхээр
в) Батболдын Батхуягийг	769,630	саналын эрхээр
г) Түдэвийн Доржготовыг	769,360	саналын эрхээр
д) Жамбаагийн Чимэдцэрэнг	1,129,083	саналын эрхээр
е) Ганхуягийн Оюунгэрэлийг	1,129,013	саналын эрхээр

Хараат бус гишүүнээр:

м) Батнасангийн Бямбасүрэнг	964,300	саналын эрхээр
н) Сахьяагийн Итгэл	961,717	саналын эрхээр
о) Базаррагчаагийн Сийлэгмааг	1,129,241	саналын эрхээр

- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг дор дурдсанаар тогтоов. Үүнд:
- | | | | |
|--|------|--------|-----------------|
| а) Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 4,500,000 төгрөгөөр; | 63.1 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 912,000 төгрөгөөр; | 63.1 | хувийн | саналаар батлав |
| б) Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,080,000 төгрөгөөр; | 63.1 | хувийн | саналаар батлав |
| в) Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 1,800,000 төгрөгөөр; | 63.1 | хувийн | саналаар батлав |
- 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдэд олгох жилийн урамшууллын дээд хэмжээг компанийн 2015 оны жилийн орлогын 2.0 хүртэл хувиар;
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын жилийн зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 10,250,000 төгрөгөөр

1

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Тооллогын комиссын 2015 оны 04
дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг
шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж,
бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн Дүрмийн 7.2.4 дэх заалт, Тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Дор дурдсан хүмүүсийг Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр:

Лутаагийн Буянбат
Лутаагийн Энхнасан
Батболдын Батхуяг
Түдэвийн Доржготов
Жамбаагийн Чимэдцэрэн
Ганхуягийн Оюунгэрэл

Хараат бус гишүүнээр:

Батнасангийн Бямбасүрэн
Сахьяагийн Итгэл
Базаррагчаагийн Сийлэгмаа

ХУРЛЫН ДАРГА,



Л.БУЯНБАТ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргын
цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлыг
батлах тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын
2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ
НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалингийн хэмжээг 4,500,000 төгрөгөөр, ердийн гишүүний сарын цалингийн хэмжээг 912,000 төгрөгөөр, хараат бус гишүүний сарын цалингийн хэмжээг 1,080,000 төгрөгөөр, нарийн бичгийн даргын сарын цалингийн хэмжээг 1,800,000 төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдэд олгох жилийн урамшууллын дээд хэмжээг компанийн 2015 оны жилийн орлогын 2.0 хүртэл хувиар тогтоосугай.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны дотоод ажлын зардлын төсөв (цалин, урамшууллыг оролцуулахгүйгээр)-ийг 10,250,000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ